

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/67/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Н.Отгонцэцэг
Утас: 70373089 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

43000 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14 у/ба
Утас: 7027-5858, Факс: (070) 7027-3288
E-mail: darhanuul@audit.gov.mn

дэлг. од. дс № 181
Төвийн _____-ийн № _____

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ЧАГНААДОРЖ ТАНАА**



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Д.МӨНХБАЯР/



009070130

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	165,578.3	195,236.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,243,543.8	3,467,785.8
	Нийт хөрөнгийн дүн	3,409,122.1	3,663,021.8
	Нийт өр төлбөрийн дүн	153,333.8	373.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,255,788.3	3,662,648.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,409,122.1	3,663,021.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,259,757.6	1,399,491.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	981,736.9	990,523.1
	Үйл ажиллагааны үр дүн	278,020.7	408,968.0
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(121,248.0)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	278,020.7	287,720.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,977,767.6	3,255,788.3
	Тайлант оны үр дүн	278,020.7	406,860.0
	Эцсийн үлдэгдэл	3,255,788.3	3,662,648.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	749,245.1	1,006,489.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	714,113.8	860,680.4
	Үйл ажиллагааны ЦМГ	35,131.3	145,808.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	651,192.2	866,831.4
	Урсгал зардал	625,660.9	747,691.4
	Хөрөнгийн зардал	25,531.3	119,140.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	651,192.2	866,831.4
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	640,575.2	848,803.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	10,617.0	18,028.1

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хонгор сумын ЗДТГазар нь орон нутагт төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Хонгор сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд нь шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллийг хугацаанд нь оруулсан боловч 415,927.7 мянган төгрөгийн 47 мэдээллийг мэдээлээгүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,775,697.2 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс, 1,345,803.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 994.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 428,899.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

➤ Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг 658,132.6 мянга, үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлогыг 571,470.8 мянга, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төсвийн гүйцэтгэлийг 115.826.7 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлсэн.

➤ Монгол Шуудан ХК-тай тооцоо нийлсэн акт, лавлагаагаар 373.5 мянган төгрөгийн өрийн үлдэгдэлтэй тул өглөгийг бүртгэх.

Төлбөрийн акт

Тайлант онд үр дүнгийн урамшуулал 994.6 мянган төгрөгийг давхардуулан олгосон тул төлбөрийн акт тогтоов.

Зөвлөмж

1. Цалин, хөлс, нэмэгдэл урамшлын зардлаас аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/200 дугаар захирамжаар Хонгор сумын Засаг дарга Т.Атархишигт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,052.2 мянга, Хонгор сумын ЗДТГ-ын даргын 2021 оны Б/54 дугаар тушаалаар 1 ажилтанд 697.4 мянган төгрөгийн мөнгөн шагналыг тус тус олгосон тул төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаал, Сангийн сайдын 2021 онд баталсан “Эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх,

2. Тус байгууллагын ажилчдад 11,221.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтээр үнэлэхгүйгээр олгосон тул Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Сангийн сайдын 1996 оны “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ыг мөрдөж, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх,

3. Тус байгууллага нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 58,937.1 мянган төгрөгийн 6 орлогын гүйлгээ, 56,756.2 мянган төгрөгийн 3 худалдан авалт, 300,234.4 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах 38 шийдвэрийг тус тус мэдээлээгүй тул Шилэн дансны тухай хуулийг мөрдөн ажиллаж, цаашид дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжүүдийг өгсөн.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ									

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	5	1,359,769.5	2	1,345,803.6	1	994.6			2	12,971.3
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	1	415,927.7							1	415,927.7
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
	НИЙТ ДҮН	6	1,775,697.2	2	1,345,803.6	1	994.6			3	428,899.0